

МОНГОЛЧУУДЫН ТӨВӨД ХЭЛТ СУРГААЛЫН ЗОХИОЛ: ҮЗЭЛ САНАА, ҮР НӨЛӨӨ

Далантайн ЦЭРЭНСОДНОМ

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Утга зохиол судлалын салбарын ЭШТА, академич

Дамбийхорлоогийн НАРАНЦЭЦЭГ*

Монгол Улс, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Сурвалж бичиг, төвөд судлалын салбарын ЭШТА, доктор (Ph.D), профессор

Содномдоржийн ЯНЖИНСҮРЭН**

Монгол Улс, МУИС-ийн ШУС-ийн Философи, шашин судлалын
тэнхимийн багш, доктор (Ph.D) профессор

Хураангуй: Монголчуудын төвөд хэлээр бичсэн зохиол бүтээл нь уламжлалт мэдлэг ухааны бүхий л салбарыг хамарсан байдаг ч төрөл зүйлийн хувьд түүхийн зохиол, уран зохиолын дурсгал, шашин хийгээд философийн зохиол гэх мэт ерөнхий хэдэн бүлэгт ангилж иржээ. Уран зохиолын дурсгал нь тахил буюу мөргөлийн үг, төгсгөлийн шүлэг, шигтгэл шүлэг, залбирал ерөөлийн шүлэг, магтаал шүлэг, дуулал шүлэг, сургаалын шүлэг, үг яриа, захиа бичиг, намтар солдэв, үлгэр догжид зэрэг олон зүйл бөгөөд үүнд монголчуудын төвөд хэлээр бичсэн сургаалын зохиол чухал байр суурь эзэлнэ.

Сургаалын зохиолыг хэнээс хэнд хандаж сургаснаар нь хаанаас ард иргэддээ, улсын багш, хааны багшаас төрийн эзэн хаан, хан хөвгүүдэд, шашны ихэс дээдэс лам нараас шашин номынхоо шавь, хуврагуудад, эсвэл ард иргэдэд сануулга болгосон юм уу, багшаас шавьд захисан, эсвээс бичгийн мэргэдээс нийт ард олонд хандсан хэмээн олон ангилж болно. Сургаалын зохиол нь хүний аж төрөх ёс, ёс суртахуун, зан үйл, ажил үйлдэлд нь заан сургасан, зөвлөсөн утга агуулгатай, ихэнхдээ хүний өдөр тутмын ахуй амьдралын алдаа, оноотой бодит байдалд тулгуурлан зөв аж төрөхөд нь хэрэгтэй санаж сэрэх үгийг эсрэг

* © Д.Наранцэцэг 2024

E-mail: narantsetseg_d@mas.ac.mn

** © С.Янжинсүрэн 2024

E-mail: yanjinsuren@num.edu.mn

тэсрэг шинжүүдийг зэрэгцүүлэн тавьж, харьцуулал харшууллын аргаар, цөөн үгээр гүнзгий санаа илэрхийлэн, шүлэглэсэн болон хосолмол хэлбэрээр бичигдсэн байдаг.

Монгол лам нарын сүнбүм зохиолд төвөд хэлээр бичсэн сургаалын зохиол үлэмжхэн байна. Хэн нэгний сүнсүмд ороогүй, зохиогч нь тодорхойгүй боловч ард түмний дунд гар дамжин уншигдсаар, хуулбарлан түгээсэн сургаалын зохиолууд ч олон бий

Сургаалын зохиол нь сэдвийн хувьд өргөн, үг хэл уран, утга гүн байхын зэрэгцээ аливаа сайн муу явдлыг хүнд танин мэдүүлэх, сурган хүмүүжүүлэх ач холбогдолтой тул хуучин цагт шинэ тутам бичиг үсэг сурч буй хүмүүст зориуд уншиж судлуулдаг уламжлалтай байв.

Түлхүүр үгс: монголчуудын төвөд хэлт утга зохиол, сургаалын зохиол, үзэл санаа

1. Удиртгал

Монголчууд эртнээс дэлхийн олон улстай соёлын харилцаа, ялангуяа Төвөд оронтой бат зузаан хэлхээ холбоо тогтоожээ. “Өнө эртний соёлт Энэтхэгийн утга зохиол түүхийн урт хугацааны турш Төвөдөөр дамжин Монголд нэвтэрч байлаа. Мөн Төвөдийн утга зохиолоос монголчууд эх хэл дээрээ үлэмжхэн орчуулсан байна. Энэтхэг, Төвөдийн утга зохиолын нэг хэсэг нь монгол орны соёлын шимт хөрсөнд идээшиж зохицоод, сүүл сүүлдээ бүр монголжиж гүйцсэн байна. Нөгөө талаар Монголын сэхээтэн нар зөвхөн орчуулга хийгээд зогссонгүй, өөрсдөө төвөд хэлээр үлэмжхэн хэмжээний ном зохиол бичсэн нь эргээд Төвөдийн ард түмний хүртээл болж, тэдний оюуны соёлд ихээхэн нөлөөлжээ. Энэ бол хариу нөлөөлсөн хэрэг бөгөөд монголын судлалд эрхбиш анхаарч үзүүштэй сонин үзэгдэл юм. Төвөд хэлээр зохиол бичих уламжлал бол монголын утга зохиол дахь бүхэл бүтэн урсгал болно. Ийм бүтээлүүдийг эрдэм шинжилгээний сүүлийн үеийн ном хэвлэлд төвөд хэлт утга зохиол гэж нэрлэсэн нь үзэгдэнэ¹⁴ (Ёндон:1976, 579). Эдүгээ монгол хүний өөрийнхөө газар орны онцлог, хэл соёл, зан үйл, ёс заншилд зохируулан төвөд хэлээр бичсэн зохиол бүтээлийг ерөнхийд нь монголчуудын төвөд хэлт утга зохиол хэмээх болсон нь хэдийнээ тогтсон ойлголт, тодорхой салбар судлагдахууныг илэрхийлсэн нэр томьёо болоод байна.

Монгол хүний төвөд хэлээр туурвисан зохиол бүтээлийг бүртгэн судлах ажил өнгөрсөн зууны сүүл хагасаас эхэлсэн гэж хэлж болох бөгөөд Шанжийн Иштавхайн 1958 онд хийсэн лам нарын бүтээлийн бүртгэлд суурилж, Гандантэгчэнлин хийдийн хамба лам, хамба номун хаан Самаагийн Гомбожав абугай 1959 онд хуралдсан Монголч эрдэмтдийн анхдугаар их хуралд “Монголчуудын төвөд хэлээр зохиосон зохиолын зүйл” илтгэлийг хэлэлцүүлсэн ба тус илтгэлд 204 монгол ламын төвөдөөр бичсэн зохиол бүтээлийн тоймыг

¹⁴ Монгол хүний төвөд хэлээр бичсэн зохиолыг төвөд хүний бичсэн зохиолоос ялгахын тулд төвөд хэлт утга зохиол хэмээн академич Ш.Бира анх нэрлэжээ (Бира, 1960:3).

үзүүлсэн байдаг. Түүнээс хойш монгол хүний төвөд хэлээр бичсэн зохиолын судалгаа өргөжсөөр, зохиолуудыг зөвхөн дахин хэвлэх, орчуулах бус судлах, агуулгыг нь нээн илрүүлэх, каталогжуулах ажил тасралтгүй хийгдсээр, эдүгээ төвөд хэлээр сүмбүм зохиол туурвисан 500 гаруй эрдэмтэн байгаа нь судалгаанаас тодорхой болоод байгаа ба судалгааг эрчимжүүлбэл энэ тоо нэмэгдэх нь дамжиггүй юм.

2. Судалгааны арга зүй

Бид энэ өгүүлэлдээ эрт цагаас монголчуудын ёс суртахууны эх сурвалж болсоор ирсэн сургаалын зохиолуудыг харьцуулан шинжилж, төвөд хэлээр бичсэн сургаалын зохиолын үзэл санааг гаргав. Мөн өнөө цагт хүүхэд залуусыг сурган хүмүүжүүлэхдээ уламжлалт сургаалын зохиолоос хэрхэн ашиглаж буйг 2017 онд улсын хэмжээнд хийсэн социологийн судалгааны үр дүнд үндэслэв. Энэ санал асуулгад сургаалаар хүмүүжүүлэх уламжлал, сургаалын зохиолын үр нөлөө өнөө цагт ямар байгааг “Тоть шувууны сургаал” зохиолд гардаг охин, хөвгүүн хүнд зайлшгүй байх ёстой сайн чанар, цэрвэн цээрлэвэл зохих муу шинжүүдийг тодорхойлж хэлдэг байдлаар жишээ болгон өгүүлэхийг хичээсэн болно.

3. Судалгааны эх хэрэглэгдэхүүн

Монголчуудын төвөд хэлт сургаалын зохиолын баялаг уламжлалтай ард түмэн билээ. Бид энэхүү өгүүлэлдээ Зая гэгээн Лувсанпэрэнлэй, Ламын гэгээн Лувсанданзанжанцан, Сүмбэ хамба Ишбалжир, Цахар гэвш Лувсанцүлтим, Алшаа лхаарамба Агваандандар, хамба номун хан Агваанхайдав, Ноён хутагт Данзанравжаа, Эрдэнэ мэргэн бандида Агваан-Ишсамбуу, Гүнгийн Зуугийн гэгээн Ишданзанванжил, Халхын Сэцэн ханы Нанзад аграмба, Гүнтан гэгээн Гончигдамбийдонмэ нарын бичсэн сургаалын зохиолыг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон ашиглалаа.

4. Судалгааны оршил

Сургаалын зохиолын төрөл зүйл нь монголын уран зохиолд эртний түүхтэй юм. XIII зууны үеийн түүх, уран зохиолын чухал дурсгал болох “Монголын нууц товчоо”-нд эртний уран сургаалын шүлэг нэлээн буй. Тэрчлэн монгол ардын аман зохиолын ерөөл, дуу, зүйр цэцэн үгэнд уран сургаалын шүлэг түгээмэл буй. Монголын олон ястны хурим найрын үг дуу ч бүхэлдээ сургаалын шинжтэй шүлэг ерөөл байдаг бөгөөд буриадын “Ууцын дуу”, үзэмчиний “Эхийн цагаан сүүний харамжийн үг”, “Хүүхэнд захих үг” зэрэг нь хүүхнээ харийн газар хадамд очоод аятай дүйтэй амьдрахыг захиж сургамжилсан агуулгатай байна.

Мөн монгол ардын цэцэн үгийн дотор хүн төрөлхтний балар эртний амьдралтай холбоотой сургамжийн үг тохиолдож байгаагаас үзвэл сургаалын зохиолын эх үүсэл нь асар эртний уламжлалтай ажээ. Жишээлбэл:

“Гадагш явах хүн амаа хичээ

Гэрт байх хүн галаа хичээ” гэсэн сургаал бол эртний гал манаж амьдарч байсан үеэс уламжилж ирсэн хуучны сургаал үг бололтой байна (Цэрэнсодном, 1976:70-71). Эрт цагаас амьдралыг таньж мэдсэн туршлага дээрээс үндэслэн үүссэн ончтой, цэц мэргэн үгсийг эхэндээ билиг сургаал гэж нэрлэж байсан ажээ. Билиг сургаал хэмээх үгийн гарлын тухайд “Билиг хэмээх нь энгийн малчин ардын ярьж өгүүлсэн цэцэн мэргэн үгсийг заана. Билиг нь эрт үед хаад ноёдын зэрэг цолны нэрийтгэл байсны зэрэгцээ тэдгээр хүмүүсийн хэлж соёрхсон сургаал соёрхол, малчин ардын өгүүлсэн цэцэн мэргэн үгсийг ч зааж байсан юм” (Сарангуа 2005:31). Үүнээс үзвэл гагц хаад ноёдын хэлсэн сургаал үгсийг хэлдэг бус ерөөсөө гүн утгат цэцэн мэргэн үгсийг “билиг” хэмээн нэрийдэж, эрдэм мэдлэгтэй хүмүүнийг ихэс зэрэгт хүндэтгэн, оюун билгээс нь суралцан, үгээр үлгэрлэн сургах уламжлалтай байжээ (Дашдэжид, 2013:128). Энэхүү билиг сургаал буюу иргэний сургаал зохиол нь “хүний ёс суртахууны хэм хэмжээ, ердийн ахуй амьдралын билиг цэцийг маш ойлгомжтой уран хурц үгээр илэрхийлэн, нэг талдаа цэцэн ухаантны, нөгөө талдаа тэнэг мунхгийн сайн муу хоёр шинж, явдал ёсыг авах гээхийн үүднээс харьцуулан жишиж” (Дугар-Нимаев, 1966:27), хүн ертөнцөд хэрхэн зөв зохистой амьдарвал таарахыг өгүүлсэн байдаг.

Иргэний агуулгатай билиг сургаалын үзэл санааны үндсэн дээр тухайн үеийн нийгэм, түүхийн нөхцөл шаардлагаар үүдэн гарч ирсэн шашин номын нөлөөгөөр нүгэл буян, амгалан хоосны агуулга нэмэгдэж, хос ёсны сургаал бүрэлдэн бий болжээ. Ингэж монголын мэргэд шашны уран зохиолд ардын аман зохиол ба бичгийн зохиолын элементийг ашиглаж бий болсон уран зохиолын нэгэн төрөл зүйл бол монголчуудын төвөд хэлт сургаалын зохиол юм.

XIII зууны үеэс баатарлаг явдлыг талархан сайшаасан эрэлхэг дайчин байхыг номлосон сургаал шүлэг зонхилж, “дайчин баатар явдал, зориг зүрхийг магтах бөгөөд бэрхшээлээс ухрахгүй түүнийг давахад сэтгэлийг хандуулж” (Дамдинсүрэн, 1957:84) байхын сацуу төр улсыг удирдан засахад санах сэрэх зөвлөгөө сургамжийг агуулсан байдаг. Судлаачдын үзэж байгаагаар энэ чиглэлийн сургаал зохиол бүр XIII, XIV зууны үеэс монголын нийгэм, үзэл санааны амьдралд тодорхой хэмжээгээр нэвтрэн орж ирсэн буддын шашны сургаал номлолтой холилдон нийлж, “Оюун түлхүүр” зэрэг тэр үеийн иргэний монгол сургаалын шүлэгт ч үзэл санааны зохих нөлөө үзүүлжээ. Их Монгол Улсын үеэс хууль цаазаар төрийг удирдахын сацуу ёс суртахуунаар ардыг удирдах үзэл санаа хүчтэй дэвшин гарч хууль, ёс суртахуун хоёр нь нийгмийг удирдах зөв арга зүй гэж хандаж байсан нь Чингис хааны билиг сургаал тэргүүтнээс тодорхой харж болно.

XVI зууны сүүл, XVII зууны эхэн үеэс монгол оронд гэлүгвийн шашин

дэлгэрч эхэлснээр буддын утга зохиолын доторх сургаалын шүлгийн сонгодог цоморлогуудаас орчуулах, тайлбарлах, тэдгээрийг бичмэл дармалаар хуулж, хувилах, олшруулж хэвлэх ажил идэвхэжсэн билээ. Бүр XIV зууны үеэс орчуулагдаж, үе бүхэнд олон орчуулга тайлбар сэлтээр дэлгэрч байсан Төвөдийн зохиолч Сажа бандида Гунгаажанцаны зохиосон “Сайн үгт эрдэнийн сан Субашид” болон XVIII зууны эхний хагасаас “Данжуур”-ын монгол орчуулгаар уламжлан ирсэн Энэтхэгийн төр ёсны алдарт найман шүлэглэл Нагаржунагийн “Зуун билиг”, “Билгийн гол модон”, “Рашааны дусал”, Чогсрэдийн “Зуун шүлэгт” болон “Дармапада”, “Уданабарга” зэрэг Энэтхэг, Төвөдийн мэргэдийн шилдэг бүтээлүүд манай уран зохиолын хөгжилтөд дэвшилтэт нөлөө үзүүлсэн юм. Ялангуяа Төвөдийн эрдэмтэн Гунгаажанцаны зохиол “Эрдэнийн сан Субашид” бол сургаалын шүлгээр үл барам нийт Монголын хуучин уран зохиолд чухал нөлөө үзүүлсэн зохиол болно.

Ардын аман цэц, билиг сургаалаас эх сурвалжтай эртний монгол сургаал шүлгийн баялаг уламжлал, Энэтхэг, Төвөдийн буддын утга зохиолоос уламжлалтай олон дэвшилтэт зохиол, шилдэг орчуулгын нөлөөгөөр “Урадын мэргэн гэгээний сургаал”, “Тоть шувууны сургаал”, “Нэгэн үсгийн эрдэм хэмээх сургаал”, “Авах гээхийн дөрвөн мөрт шүлэг”, “Орчлонгийн сав шимийн дуулал” зэрэг хос ёсны сургаал боловч иргэний агуулга давамгайлсан сургаал нэлээд зохиогдсон юм.

Гэсэн хэдий ч шашны номлол бүхий хос ёсны сургаалын шүлгийг монголд бурхны шашин хүчтэй дэлгэрсэн үеэс буюу XVII-XVIII зууны үед цоо шинээр гарсан зүйл гэж ойлгож болохгүй юм. Учир нь XIV зууны эхэн үеэс буяны ач тусыг номлосон томоохон сургаалын шүлгийг монгол хэлээр зохиож, модон бараар дармаллаж байсныг Берлин хотын номын санд хадгалагдаж байгаа “Турфаны олдвор” мэдээлж байна. Үүнд: “Турфаны олдворын тасархай хуудагт хүн хэрвээ буян эс үйлдвэл гурван муу заяаны нэгэн болох бирдийн оронд төрнө гэсэн агуулгатай 35 мөр шүлэг байгаа юм. Энэ нь Монголд XVI зууны сүүл, XVII зууны эхээр бурхны шашны нэгэн чиглэл болох шарын шашин хүчтэй дэлгэрч, тэр үеийн сэхээтэн лам нарын ихэнх нь үндэсний бичиг үсэг, соёл боловсролын хүрээнээс тасарч, Энэтхэг, Төвөдийн эрдэмтэн лам нарын зохиол бүтээлийг даган дуурайсан маягтай хос ёсны шүлэг сургаалыг төвөд хэлээр зохиох явдал нэн олон болж ирэв (Цэрэнсодном, 1976:73).

5. Судалгааны хэсэг

Монголчуудын төвөд хэлт сургаалын зохиолд монгол аман зохиолд элбэг байдаг ан амьтан, араатан жигүүртний авир төрхтэй адилтган зүйрлэх маягаар буюу эхний мөр шадад сургаалын шинж бүхий шүлэг, дараагийн мөр шадад түүнтэйгээ зохилдох үлгэр адилтгалыг дагалдуулал болгон хүний сайн муу олон шинж чанарыг эсрэгцүүлэн харшуулж, ижилсүүлэн зэрэгцүүлэн дүрслэх байдлаар ертөнцийн хүний ёс суртахууны хэм хэмжээ, ердийн амьдралын

шаардлагад тохирсон үзэл санаагаар өөр бусадтай тааран зохицож явахыг сургамжилсан явдал элбэг байна. Ингэж “шашин гүн ухааны ойлголтыг аман зохиолын өгүүлэгдэхүүнээр зураглан харуулах нь Энэтхэгийн буддизмд ихэд дэлгэрсэн номлолын нэгэн шалгарсан арга байсан юм. Уг арга Энэтхэгээс Төвөдөд уламжлан ирсэн” (Ёндон, 1980:11) байна. Монголд ч энэ аргаар буддын номлол сургаалын анхны мэдэгдэхүүнийг шашин номын боловсролгүй жирийн олон түмэнд хүргэхийн тулд ардын аман зохиолын өгүүлэгдэхүүн, өгүүлэмжийг ашиглан, монгол хүний өдөр тутмын ахуй амьдрал, зан заншлын дүр дүрслэлээр нэмэн дэлгэрүүлж, хэн хүн ойлгоход хялбар туурвисан байдаг нь энэ чиглэлийн сургаал ард олны дунд түгэн дэлгэрэх, хүлээн авч амьдрал ахуйдаа баримтлах хэм хэмжээ болгоход нөлөөлжээ. Ингэж сургамжлахдаа дан ганц жирийн ард иргэдийн өөр хоорондоо эвтэй зүйтэй амьдрахыг сургасан биш тухайн нийгмийн амьдралд, сүм хийдийн орчинд гарч байгаа гэм алдал, ихэс ноёдын ёс суртахууны хэм хэмжээний алдагдал, цагийн байдалд ч шүүмжлэлтэй хандаж, учрыг ухуулах, уг шалтгааныг өгүүлэх зэргээр сурган сэнхрүүлэх зарчмыг барьсан байна. Үүнд Халхын Зая бандида Лувсанпэрэнлэй, Их хүрээний хамба Агваанхайдав, Цахар гэвш Лувсанцүлтим, Тавдугаар Ноён хутагт Данзанравжаа, Эрдэнэ мэргэн бандида Агваан-Ишсамбуу нарын шүүмжлэлт зохиолуудыг дурдаж болно. Тэдгээр лам нарын шүүмжлэлт аястай зохиолуудыг судлаад Ч.Жүгдэр абугай монголын нийгэм улс төрийн сэтгэлгээний түүхийг үечлэхдээ нэгэн бүхэл үеийг “Шүүмжлэлт, ардчилсан үзэл санааны үе” гэж томьёолсон нь санамсаргүй хэрэг биш болно. Энэ үед нийгэмд, шашны институциудад шинэчлэл хийх анхны санаачлага үр хөврөл төлжиж эхэлжээ. Чухам тэр үеэс сайн сайхан, саар мууг ятган сэнхрүүлсэн сургаалын зохиолыг хүүхэд багачуудад үсэг ном сурч эхлэх үеэс нь уншуулж цээжлүүлж, учрыг ухааруулж ирсэн бололтой. Ийм зохиолын нэгэн жишээ бол Тобагийн гэгээний зохиосон “Тоть шувууны сургаал” хэмээх зохиол болно.

“Тоть шувууны сургаал” нь бичмэл, дармал олон хувилбараар өргөн дэлгэрчээ. Үүнийг зохиогч “Тобагийн гэгээн нь хэдий үеийн ямар хүн болох нь тодорхойгүй. Хуврагийг хүндлэхгүй хүнийг хамгийн мууд тооцсоноос үзвэл энэ сургаалыг зохиогч нь бурхан шашны ёс горимыг сайтар мэддэг хувраг хүн байсан нь магад” (Дамдинсүрэн, 1959: 472) хэдий ч зохиолд ардач иргэний шинж чанартай хэсэг цөөнгүй буй. Тоть шувууны сургаалд “эрдмийг сурагч хувраг”, “буруу явдалт хувраг”, “сайн явдалт ноён”, “эргүү бядуу ноён”, “зохист сайн ард”, “мунхаг муу ард”, “самбаа сайт эхнэр”, “санаа муу эхнэр”, “эрхэм сайн хөвгүүн”, “эгүүр муу хөвгүүн”, “саруул ухаант охин”, “асар муу охин” гэх мэтээр хүний сайн, муу шинжийг ёс суртахууны үнэлэмжийн ойлголтуудаар дамжуулан илэрхийлж байсан нь гэр бүлийн амьдрал, эхнэр нөхөр, үр хүүхдийн анхаарвал зохих зүйл, даган баримталбал зохих зарчим, ард түмний өдөр тутмын амьдралдаа баримтлах хэм хэмжээ нь болж байжээ (Тунгалаг, 2010:150). Тухайлбал, Тобагийн гэгээний “Тоть шувууны сургаал”-д хувраг хүний сайн муу шинжийг “...Адил тангарагт нөхрөө хүндлэн, алив нууц уддисыг хадгалан,

алагчаалалгүй сэтгэлээр амьтныг энэрэн, амарлингуй дүрээр номхон явагч ба ахуй их эрдмийг сурсан боловч асар омоггүй номхон болоод аргаар амьтныг номд оруулан, анхааран хичээгч хувраг...” хийгээд “...Атаархах сэтгэлээр дээдсийг доромжлон, адил тангарагт нөхдөө аль муугаар сонжин, уур хилэнгээр бусдыг хөнөөгч ба өчүүхэн сурсан эрдмээ оморхон, өөрийн биеийг магтан өргөмжлөн, өших сэтгэлээр мэргэдийг доромжлон, өөдгүй нүгэл үйлдэгч хувраг...” хэмээн эсрэгцүүлэн өгүүлжээ.

Мөн төрийн жир эр хар хүний сайн муу явдлыг “...Ажил байдлаа алдалгүй арвижуулаад, адгуус малаа алдалгүй өсгөөд, алба татвараа саадгүй төлөөд, ажиггүй сайн суугч ба ашдын ноён эздээ зохистойгоор хүндлэн, айлдсан зарлигийг ёсоор гүйцэтгэн, ах дүүдээ ая тал сайтай асар зохист ард” хийгээд “Хэтэрхий бардам үг хэлж яван, хэргээ үл бүтээн буцаж ирээд, хэрэлдэн гэргий юүгээн зэмлэн хараагч хэлшгүй муу ард..” гэж ялган салгаж тодорхойлоод, эцэст нь “Тэнэг адгуус үхрийг сургаваас тэрэгний замаар явдаг биш үү. Төгс дээдсийн сургасан зарлигийг түүтгэрэлгүй анхааран авагтун та. Адгийн муу үнэг хэдий хуцавч, арслан зааныг яахан айлган чаднам. Адгуус төрөлт тоть шувуу би ч алдарт хүнийг яахан сургаж чадмуй. Үүдэнд тэжээсэн нохой хуцваас, эд малаа эргэж үзэх мэт эдгээр сургаж хэлсэн үгийг минь сонсох болов уу. Ай өчүүхэн хэтийн галаар уул талыг түймэрдэх мэт асрах сургамжийг хэлсэн буянаар амаргүй орчлон хоосон болох болтугай” (Хишигсүх, Янжиндулам, 2021:97-102) гэх зэргээр ятган сануулж өгүүлэх бөгөөд үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1.

	Сайн шинж /бадаг шүлгээр/	Муу шинж /бадаг шүлгээр/
Хувраг, ноёдын явдал үйл	9	11
Эр хүний явдал үйл	8	7
Эхнэр хүний явдал үйл	9	12
Хөвгүүн хүний явдал үйл	3	3
Охин хүүхдийн явдал үйл	3	4

Тоть шувууны сургаалд хүний сайн, муу шинжийг үзүүлсэн нь

Хүснэгтээс харахад дадуулбал зохих сайн шинжээсээ цээрлэвэл зохих муу шинж олон байгаа нь сайн сайхныг үлгэр дуурайл болгож, муу муухайг жигшүүлэх гэсэн зорилготой байна. Ингэхдээ аливаа зүйлийг дахин дахин давтан хэлж байж ухааруулна гэсэн санааг илэрхийлэхийн тулд сонссон дуулснаа давтан дуурайн хэлдэг тоть шувуугаар төлөөлүүлэн “Тоть шувууны сургаал” гэж нэрлэсэн байж болох юм.

Аливаа сургаалын шүлэг нь хүнд сайн муу явдлыг танин мэдүүлэх, алдаа дутагдлыг нь ойлгуулах, явдал мөрийг нь засах, сурган хүмүүжүүлэх, соён гэгээрүүлэх, идэвх урмыг нь сэргээх зэрэг зорилготой, сурган хүмүүжүүлэх чухал ач холбогдолтой учраас тэдгээрийг шинэ тутам бичиг үсэг сурч буй хүмүүст зориуд гэрийн сургуулиар дамжуулан уншиж судлуулдаг, эцэг эх нь ч үр хүүхдэдээ цээжлүүлэн, ухааныг задлан, учрыг ойлгуулдаг уламжлалтай байжээ. Энэ уламжлал өнөө цагт ямар байдалтай байгааг бид “Монголчуудын

гэр бүлийн орчин дахь үндэсний соёл, чиг хандлага” төслийн хүрээнд явуулсан санал асуулгаар тодруулахаар оролдсон юм. Энэ санал асуулгад сургаалаар хүмүүжүүлэх уламжлал өнөө цагт ямар байгааг “Тоть шувууны сургаал” зохиолд гардаг охин, хөвгүүн хүнд зайлшгүй байх ёстой сайн чанар, жигшин цээрлэвэл зохих муу шинжүүдийг тодорхойлж хэлдэг байдлаар жишээ болгон авсан бөгөөд үр хүүхдээ хүний мөс чанар сайтай хүн болгон төлөвшүүлэх, ирээдүйн амьдралд хөл тавихад ихээхэн тус дөхөм болдог байсан уламжлал өнөөдөр ямар байгааг доорх хэсгээс харж болно.


“Та хүүхдээ хүмүүжүүлэхэд “сайн болон муу хүү, охины шинж”-ийн талаар “Монголчуудын уламжлалт сургаалыг хүүхдэдээ хэлж сургадаг уу?” хэмээн асуулга авахад судалгаанд хамрагдсан хүмүүсийн 40.9% нь хэлж сургадаг, 36.4% нь огт хэлж сургадаггүй, 14.3% нь заримдаа гэж хариулсан байна. Үүнээс үзвэл сайн, муу хөвгүүн, охины шинжийн тухай хэлж сургадаг уламжлал өнөө цагт тодорхой хэмжээнд хадгалагдаж байна.

График 1. “Сайн болон муу хүү, охины шинж”-ийн талаарх сургаалыг хэлж сургадаг байдал²



Боловсролын түвшнээр нь үзэхэд, тусгай боловсролтой хүмүүс боловсролын бусад түвшний хүмүүсээс илүүтэйгээр “сайн, муу хүү, охины шинж”-ийг хэлж сургадаг бол дээд боловсролтой хүмүүс хамгийн багаар хэлж сургадаг ажээ. Гэхдээ боловсролын түвшнээс үл хамааран энэхүү сургаалыг хэлж сургадаг байдал цаашдаа мартагдаж болзошгүйг судалгааны дүн харуулж байна.

График 2. “Сайн болон муу хүү, охины шинж”-ийн талаарх сургаалыг хэлж сургадаг байдал, боловсрол³



Насаар нь авч үзвэл, 40-өөс дээш насныхан “сайн, муу охин, хөвгүүний

² Гэр бүлийн орчин дахь үндэсний соёлын өнөөгийн байдал, чиг хандлага. Социологийн судалгааны тайлан. СУСХ. УБ., 2016. 72-р тал

³ Мөн тэнд. 105-р тал

шинж”-ийн тухай мэдлэг бусад насныхнаас илүү байж, хэлж сургадаг бол 40-өөс доош насныханд энэ талаарх ойлголт мэдлэг дулимаг байна.

График 3. “Сайн болон муу хүү, охины шинж”-ийн талаарх сургаалыг хэлж сургадаг байдал, нас⁴



Аймаг, хотоор харьцуулж үзэхэд Баян-Өлгийн аймгийн иргэд хамгийн өндөр буюу 78.3% нь дээрх сургаалыг баримталдаг гэж хариулсан нь хүүхэд хүмүүжүүлэхдээ тэдний ухамсар, төлөвшилд нөлөөлөхүйц сургаал, үг хэллэг хэрэглэх зэргээр хүмүүжлийн уламжлалт арга ухааныг илүү хадгалж байгаа бол бусад хот, орон нутагт энэ уламжлал алдагдаж байгааг дээрх үзүүлэлт харуулж байна.

График 4. “Сайн болон муу хүү, охины шинж”-ийн талаарх сургаалыг хэлж сургадаг байдал ба аймаг, хотоор



Ийнхүү сургаал зохиолыг хэлж сурган хүүхдэд ёс суртахууны хүмүүжил төлөвшил бий болгодог монгол уламжлалыг Тобагийн гэгээний зохиосон Тоть шувууны сургаалын “сайн, муу охин, хөвгүүний шинж”-ээр жишээлэн авч үзэхэд сургаал зохиол хэлж сургадаг уламжлал тодорхой хэмжээнд байгаа мэт боловч залуу үеийнхэнд энэ талаарх мэдлэг дутмаг байгаа нь цаашид энэ уламжлал мартагдаж болзошгүйг анхаарууштай болжээ (Нинжбадгар, 2018:104).

Бид энэхүү социологийн судалгааны явцдаа үр хүүхдээ төлөвшүүлэх арга ухааны талаарх мэдлэг, мэдээллийг хаанаас, ямар эх сурвалжаас олж авдаг болохыг бас тодруулсан юм. Судалгаанд нийт 2230 хүн хамрагдсан бөгөөд монголчуудын үр хүүхдээ хүмүүжүүлэн төлөвшүүлэх арга ухааны талаарх мэдлэгийг судалгаанд хамрагдагсдын 42,2% нь буюу 925 хүн телевиз, радио, ном, хэвлэлээс, 35,1% нь буюу 782 хүн ахмад үеэсээ, 13,2% нь буюу 289 хүн интернет, цахим орчноос олж авдаг бол гэсэн бол 4,7% нь болох 104 хүн

⁴ Мөн тэнд. 101-р тал

мэдээлэл авдаггүй, тийм орчин бүрэлдээгүй, 4,1% нь буюу 90 хүн голчлон сургалт, судалгаанаас энэ талын мэдээлэл олж авдаг гэж хариулжээ.

Хүснэгт 2.

	Тоо	Хувь	Хамрагдсан хувь	
Хамрагдсан байдал	Ном, хэвлэл	925	41.5	42.2
	Интернет	289	13.0	13.2
	ТВ, радио	90	4.0	4.1
	Ахмад үеэс	782	35.1	35.7
	Мэдээлэл авах орчин бүрэлдээгүй	104	4.7	4.7
	Нийт	2190	98.2	100.0
Хариулаагүй		40		1.8
Нийт		2230	2230	100.0

Монголчуудын үр хүүхдээ хүмүүжүүлэн төлөвшүүлэх арга ухааны талаарх мэдлэгийг олж авдаг мэдээллийн эх сурвалж

Энэ асуулгад үр хүүхдээ сурган хүмүүжүүлэх мэдлэг ухааны талаарх мэдлэг, мэдээллийг судалгаанд оролцогсдын ихэнх нь буюу 42.2% ном, мэдээллийн хэрэгслээс авдаг гэж хариулснаас улбаалаад бид цаашид сургаалын зохиолыг нас насны онцлогт тохирсон, өнөө цагийн уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц, товч, ойлгомжтой, хялбаршуулсан тайлбартайгаар хэвлэн нийтэлж тархаах, шат шатны боловсролын сургалтын агуулгад оруулах шаардлагатай болсныг харуулж байна.

6. Судалгааны үр дүн

Монголчуудын дунд хүний зан суртахууныг засан сайжруулах, төрийн практик үйл ажиллагааг удирдахад чиглэсэн төр иргэний уугуул монгол сургаал ардын аман зохиолын үзэл санааны баялаг уламжлалыг түшиглэн хөгжиж байлаа. Иймэрхүү сургаалын үзэл санааны цаашдын хөгжилд түүхийн шинэ нөхцөл шаардлагаар үүдэн гарч ирсэн шашин номын сургаал үзэл санааны зохих хазайлт нөлөөг үзүүлсэн юм. Энэ нь буддын шашны утга зохиол Энэтхэгээс Төвөдөд, Төвөдөөс Монголд дамжин дэлгэрэх явцад тэр дундаа шашны номлолын онцгой хэлбэр болж байсан сургаалын зохиолын төрөл, бүр идэвхтэй дэлгэрэх болсон явдлаар тайлбарлагдана. Энэ их хэрэг явдалтай хамт нэгэн зэрэг дагалдаж, монголчуудын оюун санааны өсөлт хөгжилтөд чухал үр нөлөөг үзүүлж, сургаалын шүлгийг туурвин зохиоход нь жишээ дуурайл болсон Энэтхэг, Төвөдийн иргэний чиглэлтэй олон шастир сургаал бол ийнхүү уугуул монгол сургаалын шүлгийн үзэл санааны гадаад нэг эх сурвалж болоход хүрсэн юм. (Хүрэлбаатар, 1998:10).

Уугуул монгол буюу иргэний ёсны сургаал давамгайлсан зохиолд хүний энэхэн ертөнцөд хэрхэн зөв шулуун, эвтэй зүйтэй, аятай нийцтэй амьдрахыг заан

чиглүүлсэн өнгө аястай. Ингэхдээ адилтгал зүйрлэл, харшуулал харьцуулал зэрэг уран зохиолын дүрслэн илэрхийлэх олон аргыг хэрэглэж, хийсвэр ойлголтыг нүдэнд үзэгдэхүйц болгон өгүүлсэн нь ард олон шууд амар хялбар ухан ойлгож хүлээж авч, сэхээрч сэрэхийг бодолцсон байж болох юм. Жишээлбэл, Сүмбэ хамба Ишбалжирын “Хүмүүний номын ёсны шастир үзэсгэлэнт цэцгийн эрх” шүлэгт “хүн энэ насандаа энэ ертөнцөд хэрхэн зөв зүйтэй амьдрахыг номлодгоороо “хүн ёсны” буюу “төр ёсны” гэсэн нэртэй зохиолуудын бараг төлөв нь иргэний маягийн агуулгатай байдгийн жишээ болно. Энэ шүлэгт:

bye brag mkhas blun gnyer bya spyod mi ‘dra//

Ялангуяа мэргэн тэнэгийн

Явдал үйлс нь онд ондоо

ngang ba mtshor ‘bab bya rgod dur khrod ‘bab//

Нууран дээр галуу бууна

Хүүрэн дээр тас бууна.

blo ldan rig gnas ya mtshan rigs la mgu//

don med don log don dman dga’//

Сайхан эрдэмд ухаантан дурлана

Саваагүй хэрэгт мунхгууд баясна.

khu byug gnam chu phag rdzing mi gtsang ‘tshol//

Тэнгэрийн усыг хөхөө эрнэ

Хонхорын шавхайг гахай тэмцэнэ.

gangs ri rdul bral sol ba bkrus kyang nag//

Цагаан цаст уул тоосонд хиртэхгүй

Бараан хар нүүрс усанд цайрахгүй.

thang la zla zer gcong rong mun ‘bab sla// (Ишбалжир, 2)

Ээрэм талд сарны гэрэл тусамтгай

Эрэг нураанд харанхуй сүүдэр буумтгай”

гэхчлэн өгүүлснээс үзэхэд агуулгаараа ердийн төр ёсны сургаал шинжтэй бөгөөд сайн муу, зөв бурууг өгүүлэх санаагаа гаргахдаа эсрэг тэсрэг харшууллын аргыг олонтоо хэрэглэжээ. Төвөд, Монголд ихэд дэлгэрсэн иймэрхүү сургаалын зохиолуудад хүмүүнийг “мэргэн”, “тэнэг” гэж хоёр туйлд хуваагаад, мэргэнийх нь сайн явдлыг дуурайж, тэнэгийнх нь буруу явдлыг жигшихийг уриалдаг нь эртний уламжлалтай юм (Ёндон, 1976:583-584).

Цахар гэвш Лувсанцүлтим “Бүхний өдүүлбэрийг засахын шүлэг” хэмээх зохиолдоо:

phan tshun ‘khrug rtsod byed pa’i skye bo dag//

ci zhig smras kyang de yi grogs mi bya//

phog ‘thob pa dang go sa ‘phar ‘dod dag//

ngo chen bya bar smras kyang nyau mi bya// (Лувсанцүлтим, Га боть, 8г2-3)

“Алимад нааш цааш хямрал тэмцэл үйлдэгч ардууд

Алин юуныг өгүүлэвч бүү нөхөрлө

*Ашдын тэжээл хүнсийг олох ба хэргэм зэрэг дэвшихийг хүсэгчид
Амбан ноёдод нүүрчлэхийг захивч бүү сонс” хэмээн өгүүлсэн нь аливаа зүйлд
доороо суурьтай, дотроо бодолтой явахыг сахин сургамжилсан санаа юм.*

Энэ мэтээр монголчуудын төвөд хэлт сургаалын шүлэгт:

star kha ‘bras bu me tog med pa la

‘dam bu me tog ‘bras bu med tsam// (Ишбалжир, 3)

“Хушга цэцэггүй байтлаа үртэй

Хулс үргүй байтлаа цэцэгтэй”

rlung gis sgron me chung gsod nags me sbor// (Ишбалжир, 4)

“Салхинд

Бяцхан зул бөхдөг

Хөвчийн түймэр хөгждөг” гэх буюу Цахар гэвш Лувсанцүлтимийн бичсэн шүлэг зохиолд:

“Муу өвс, модны утаа гашуун

Муу чанарт ардын үг гашуун

Муу тойд банди нарын явдал гашуун

Муу сантай зуны нар гашуун” (Лувсансамдүвням, 2010:82) гэх зэргийн мөр бадаг олон байгаа нь байгалийн нарийн үзэгдлийг ажигласнаа тусгаж, цөөн оновчтой үгээр нэн уран санаа гаргаснаараа ардын зүйр цэцэн үгийг санагдуулам болжээ.

Харин шашин номын ёсны сургаалын зохиолд ертөнцийн явдлыг нөхөд хань, дайсан садан бүгдийг ялгалгүй бүгдийг энэрч хайрлан, өөрийн сэтгэлийн дотор байх мунхгийн харанхуйгаас салж ангижрахыг ятгаж сануулсан буюу эсвээс чөлөө учралт хүний төрлийг олсон энэ насандаа хэрэггүй зугаа цэнгэлээр цаг нөгчөөлгүй, цаг үргэлжид ном буянд шамдахыг уриалсан үзэл санаа элбэг. Тухайлбал, Халхын Зая бандида Лувсанпэрэнлэйн “Хос ёсны сургаал цагаан болор толь” хэмээх сургаалын шүлэгт хүний зан байр төлөв тогтуухан суурьтай ухаалаг бөгөөд гуйвж урваж шарвахгүй байхыг сургасан байдаг (Алтангэрэл, 1976:606) нь доорх мэт:

bstod dang smad la dga’ mi dga’//

rnam ‘gyur spangs te dus rtag tu//

btso ma’i gser ltar mi ‘gyur bar//

rang bzhin bzang por gnas bar bya// (Лувсанпэрэнлэй, Га боть, 4v3)

“Муулах, магтахад гоморхон, баясах

Муу дүрийг эгнэгт тэвч.

Шижир алт мэт хувиралгүй

Шинж сайнаар оршин үйлд”.

Хэдийгээр хүн хэчнээн эрдэмтэй чадалтай боловч санаа нь муу бол ашиг тус үгүй бөгөөд шадарлан нөхөрлөх хэрэггүй гэсэн санааг Гүнтан гэгээн “Сайн номлол модны шастир” зохиолдоо:

rtsa ba dug tu gnas pa yi//

me tog mdzes kyang su la mkho// (Гончигдамбийдонмэ, Жа боть 4v3)

“Дэгжүүлэх үндсэнд нь хор буй бөгөөс

Дэлгэрэх цэцэг нь үзэсгэлэнтэй боловч хэн хэрэглэх..”

gdug pa'i sprul gyis dkris pa yi//

/tsan dan ljon ba su yis bsten// (Гончигдамбийдонмэ, Жа боть 4r1)

“Асар аймшигтай хорт могой ороож бүхий

Анхилсан үнэрт зандан модыг хэн яахан хэрэглэх буй” гэх зэргээр зүйрлэн бичжээ.

Цахар гэвш Лувсанцүлтим “Хэрэггүй нөгчөөхийг тэвчихийн дуун” хэмээх сургаал шүлэгтээ:

dbyar dus ne'u gsing me tog//

sna tshogs mdzes bar bkra yang//

dgun gyi grang slur 'tshab dus//

rdul phran tsam yang med 'gyur//

“Сайхан зуны цагийн зүлгийн цэцэг нь

Сайтар үзэсгэлэнтэйгээ элдвээр мярлавч

Сац өвлийн хүйтэн шуурга ирсэн цагт

Сааргүйгээ өчүүхэн тоосны төдийхөн ч үгүй болох буй” (Наранцэцэг, 2023:79) гэсэн бол Ноён хутагт Данзанравжаа:

dgun zla'i grang reg 'onh ba yi ngon nas//

zhwa gos thug po drod ldan de bzang ngo//

gzhan gyi phywa smad 'ong ba yi ngon nas//

bzod pa'i grogs la bcol ba de bzang ngo//

Өвлийн хүйтэн цаг ирэхийн өмнө

Илчтэй дулаан хувцас сайн

Тэсэшгүй хочийг ирэхийн өмнө

Тэсвэрийг нөхөртөө найдах нь сайн (Мөнх-Отгон, 2023:153) гэж чадал тэнхээтэй байхын цагтаа юу юунаас илүү номд шамдан суралцах хэрэгтэйг хэлсэн байна.

Тэгвэл Гүнгийн Зуугийн гэгээн Ишданзанванжил бээр:

rgyud la ma sbyar rig pa gang//

phan nit hogs pa'i yon tan yin//

byes su 'bar ba'i rtswa yi me//

khyim la phan thogs ci yang med//

Сэтгэлд эс наалдсан ухаан

Сэнхрүүлж чадахгүй эрдэм мөн

Хээр ноцсон өвсний гал

Хэний ч гэрт тус болохгүй (Бираасүрэн, 2023:220) гэж, Сэцэн ханы Нанзад аграмбатан:

dreg bral sa skam sra na yang//

rlung chen phog pas ma rungs byed//

rang bzhin ngan na tshul shes kyang//
ngan dang 'grogs phral mi khyur bud//

Хөрсгүй хуурай газар бат бэх боловч

Хуй их салхинд өртсөнөөр ангайж хагарах

Хүмүүний мөн чанар муу бол ёсыг мэдсэн ч

Гайт муутай нийлмэгц хүний сүргээс мултарна (Отгонбаяр, 2023:292)

хэмээн хэдий ном эрдмийг сайтар сурсан ч, хүн чанаргүй, зөв сайхан сэтгэлгүй бол хэн хүнд болоод өөртөө ч тусгүй болохыг “хээр ноцсон өвсний гал”-тай адилтган, ёс учрыг мэдэх сайн хүнтэй нөхөрлөж явахын чухлыг сургамжлан хэлжээ.

Эдгээрээс үзэхэд ертөнцөд сайн сайхан амьдрахад хэрэг тус болох эрдэм ном сурах, эв найртай эелдэг даруу, нөхөрсөг тусч, хүнлэг энэрэнгүй байхыг чухалчилсан ертөнцийн ёс, буян нүглийг мэдэх, үйлийн үрийг сануулах зэргээр шашны үзэл номлолыг жирийн ард олонд ойлгомжтойгоор үзүүлсэн номын ёс хоёулыг хамарсан зохиолыг хос ёсны сургаал гэх бөгөөд монголд хос ёсны сургаал хөгжсөн нь “шашны утга зохиолын дотор иргэний чиглэлтэй сургаал хөгжих, түүний дотор иргэний санаа, тэр ч байтугай, ардач үзлийн зарим хэсэг шургалан орох эвтэйхэн ая далим” (Хүрэлбаатар, 1987:165) болж, улмаар монголчуудын төвөд хэлт сургаалын шүлгийн үзэл санааны гол хандлагыг тодорхойлж байна.

Дүгнэлт

Монголчуудын дунд олон үеийн туршид ихэвчлэн аман уламжлалаар тархаж ирсэн арвин баялаг билиг сургаалын хөрсөн дээр шашны өнгө аяс бүхий агуулга нэмэгдэх замаар боловсорсон номын болоод ертөнцийн хос ёсны сургаал нь Энэтхэгээс Төвөдөд уламжилж, Төвөдөөс Монголд нөлөөлөн дэлгэрэх явцдаа урлаг уран сайхан, дүр дүрслэлийн онцлог, агуулгын болон үзэл санааны шинэчлэлээр баяжин хөгжсөөр төвөд хэлт сургаалын зохиол хэмээх монгол уран зохиолын биеэ даасан төрөл зүйлийн түвшинд хүрч иржээ.

Монгол хүний төвөдөөр бичсэн сургаалын зохиол нь сургаалын аймаг (tib: bsalab bya, bsalab tshig) гэх ерөнхий нэрд хамаарах биеэ даасан шүлэг зохиол байхаас гадна монголын бичгийн мэргэдийн туурвисан олон зуун сургаал шүлэг завсрын шүлэг, (tib: tshigs bcad), гүр дуулал (tib: mgur glu), магтаал (tib: bstod pa), залбирал, (tib: gsol 'debs), захиа бичиг (tib: sprin yig), зөвөлгөө (tib: gros 'debs), үлгэр тууж (tib: rtogs brjod) гэх зэрэг уран зохиолын бусад төрөл зүйлийн дотор ч уламжлан иржээ.

Төвөд хэлт сургаалын зохиол нь ихэвчлэн хүн ардын жирийн аж явдалд сануулга сургамж болохуйц утга агуулгатай, шүлэглэсэн болон хосолмол хэлбэрээр, өдөр тутмын ахуй амьдралаас урган гарсан, алдаатай оноотой бодит байдалд тулгуурлан, өнөөгийн ертөнцийн хүнд тохируулж зөв аж төрөхөд нь

хэрэгтэй санаж сэрэх үг сургаалыг эсрэг тэсрэг хоёр шинжийг зэрэгцүүлэн тавьж, харьцуулал харшууллын аргаар, цөөн үгээр гүнзгий санаа илэрхийлж, эгэл жирийн ард олонд сайн муу явдлыг танин мэдүүлэх, алдаа дутагдлыг нь ойлгуулах, явдал мөрийг нь засах, сурган хүмүүжүүлэх, соён гэгээрүүлэх, идэвх урмыг нь сэргээх зэрэг шууд хийгээд дам зорилготой байна. Иймд хүүхэд багачууд бичиг ном сурч эхлэхтэй нь зэрэгцүүлэн сургаалын зохиолоос уншуулан цээжлүүлж, учрыг таниулах уламжлалт сурган хүмүүжүүлэх арга ухаанаа сэргээн, цаашид нас насны онцлогт нь тохирсон, өнөө цагийн уншигчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц, товч, ойлгомжтой, хялбаршуулсан тайлбартайгаар хэвлэн нийтэлж тархаах, шат шатны боловсролын сургалтын агуулгад оруулах нь зүйтэй юм.

Abstract:

The article provides an analysis of the Tibetan religious didactic literature of Mongolia. Using the example of a number of works, the author notes that in Mongolia, in didactic literature, in order to convey the content of Buddhist teachings to ordinary lay people who do not have a religious education, folklore stories and narratives were used, images of everyday life and customs of the Mongolian people were added, thereby creating an accessible for understanding a teaching that will spread among the masses and become the norm to be accepted and followed in life.

Key words: Tibetan literature by Mongolians, advisory literature

Ном зүй

Монгол хэлээр

- Алтангэрэл, Ч.** (1976) *Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн зохиолын онол*. - Монголын уран зохиолын тойм (XVII-XVIII зуун). Хоёрдугаар дэвтэр. 597-627-р тал. Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд. Улаанбаатар. [Altangerel, Ch. *Mongol zoihiolchdyn tövöddör bichsen zohiolyn onol* [A Theory of Tibetan Writing by Mongolian Authors. - Review of Mongolian literature (XVII-XVIII centuries)]. Book 2. pp. 597-627. Editor Ts.Damdinsuren] Ulaanbaatar, 1976]
- Бира, Ш.** (1977). *БНМАУ-ын соёл, түүх бичлэгийн асуудалд*. Улаанбаатар. [Bira, Sh. *BNMAU-un soyol, tüüh bichlegiin asuudald* [In the issue of culture and historiography of the People's Republic of Mongolia.] Ulaanbaatar, 1977]
- Дамдинсүрэн, Ц.** (1957). *Монголын уран зохиолын тойм*. 1-р дэвтэр. Улаанбаатар [Damdinsuren, Ts. *Mongolyn uran zohiolyn toim* [Review of Mongolian literature.] Book-I, Ulaanbaatar, 1957]
- Дамдинсүрэн, Ц.** (1959) *Монголын уран зохиолын дээж зуун билиг*. [Damdinsuren, Ts. *Mongolyn uran zohiolyn deej zuun bilig* [A hundred sample of Mongolian literature] Ulaanbaatar, 1959]
- Дашдэжид, С.** (2013). *Билиг хэмээх үгийн тухайд*. //Монгол судлал. 2013. 37-р боть. 126-132-р тал. [Dashdejid, S. *Bilig hemeeh ügiin tuhaid* [Regarding the

- word “bilig”] //Mongolian studies. 2013. Volume 37. pp. 126-132.]
- Ёндон, Д.** (1976). *Монголчуудын төвөд хэлээр бичсэн уран зохиолын тойм.* - Монголын уран зохиолын тойм (XVII-XVIII зуун). Хоёрдугаар дэвтэр. 579-596-р тал. Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд. Улаанбаатар. [Yondon, D. *Mongolchuudyn tövöd heleer bichsen uran zohiolyn toim* [A review of Tibetan literature written in Mongolian languages.] Review of Mongolian literature (XVII-XVIII centuries). Book 2. pp. 579-596. Editor Ts.Damdinsuren, D.Tsend. Ulaanbaatar. 1976]
- Ёндон, Д.** (1980) *Төвөд Монголын уран зохиолын харилцааны асуудалд.* Улаанбаатар [Yondon, D. *Tövöd Mongolyn uran zohiolyn hariltsaany asuudald* [On the Problems of Mongolian Literary Relations with Tibet.] Ulaanbaatar, 1980]
- Лувсансамдүвням** (2010) *Гэтэлгэгч дээд лам адилтгал үгүй ачит богд Сумадишилаширибадрагийн гэгээний ерөнхийн зохиол намтрыг товчийн төдий өгүүлсэн сүсгийн лянхуаг мөшөөлгөгч нарны гэрэл дээд мөрийг гийгүүлэн үйлдэгч хэмээгдэх оршив.* Монгол бичгээс хөрвүүлж, удиртгал тайлбар бичсэн Д.Цэрэнсодном, Д.Наранцэцэг. Редактор Ш.Бира. Улаанбаатар, Бемби хэвлэх үйлдвэр. [Luvsansamduvnyam, *Getelgegeh deed lam adiltgal ügüi achit bogd Sumadishilashribadragiin gegeenii erönkhiin zohiol namtryg товчийн төдий өгуулсен сүсгийн лянхуаг мөшөөлгөгч нарны герел deed мөрийг гиигүүлэн үйлдегч хемеегдекх оршив.* [Biography of Tsahar Geshe] D. Tserensodnom and D. Narantsetseg, translated from the Mongolian script and wrote an introduction. Editor Sh. Bira. Bembi printing factory, Ulaanbaatar. 2010]
- Нинжбадгар, З.** (2018) *Монгол гэр бүлийн сурган хүмүүжүүлэх ухааны уламжлал, өнөөгийн байдал.* Үндэсний соёл-гэр бүл эмхэтгэл. Редактор Ш.Эрдэнэцэцэг. 94-121-р тал. Улаанбаатар, Бемби хэвлэх үйлдвэр [Ninjbaddgar, Z. *Mongol ger бүлийн сурган хүмүүжүүлэх ухааны уламжлал, өнөөгийн байдаль* [Traditions and current status of Mongolian family education.] National culture-family bulletin. Editor Sh. Erdenetsetseg. pp. 94-121. Bembi printing factory, Ulaanbaatar, 2018]
- Сарангуа** (2005). *Монгол билиг сургаалын судлал.* Бээжин, Үндэстний хэвлэлийн хороо. [Sarangua, *Mongol bilig surgaalyn судлал* [Study of Mongolian advisory literature.] Beijing, National Press Committee. 2005]
- Тунгалаг, Д.** (2010). *Гэрлэлт, гэр бүлийн философи, ёс зүйн зарим асуудал.* Улаанбаатар [Tungalag, D. *Gerlelt, ger бүлийн pilosopi yos зүйн зарим асуудаль* [Some Philosophical and Ethical Problems of Marriage and Family.] Ulaanbaatar, 2010]
- Хишигсүх, Б., Янжиндулам, В.** (2021). *Сургаалын зохиол.* -Монголын эртний уран зохиолын сурах бичиг. 2-р боть. 72-102-р тал. Редактор Б.Хишигсүх, Г.Нарантунгалаг. Улаанбаатар. [Khishigsuh, B., Yanjindulam, V. *Surgaalyn*

zohiol [An advisory literature.] Textbook of ancient Mongolian literature. Volume 2. pp. 72-102. Editor B. Khishigsukh, G. Narantungalag. Ulaanbaatar. 2021]

Хүрэлбаатар, Л. (1987). *Энэтхэг, Төвөд, Монголын сургаалын зохиолын хэлхээ холбоо*. -Хэл зохиол судлал. Том XVIII, Fasc.2. 143-271-р тал. Улаанбаатар. [Khurelbaatar, L. Enetheg, Tövöd, *Mongolyn surgaalyn zohiolyn helhee holboo* [Links between Indian, Tibetan and Mongolian] advisory literature. - Linguistics. Volume XVIII, Fasc.2. pp. 143-271. Ulaanbaatar. 1987]

Хүрэлбаатар, Л. (1998). *Монгол сургаалын шүлэг*. -Mongolian studies. №7, 1-29-р тал. The Korean Association for Mongol Studies. [Khurelbaatar, L. *Mongol surgaalyn shüleg* [Mongolian advisory poem.] Mongolian studies. №7, pp. 1-29. The Korean Association for Mongolian Studies. 1987]

Цэрэнсодном, Д. (1976) *Сургаалын шүлэг*. - *Монголын уран зохиолын тойм* (XVII-XVIII зуун). Хоёрдугаар дэвтэр. 70-93-р тал. Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд. Улаанбаатар. [Tserensodnom, D. *Surgaalyn shüleg* [Advisory Poems.] Review of Mongolian literature (XVII-XVIII centuries). Book 2. pp. 70-93. Editor Ts. Damdinsuren, D. Tsend. Ulaanbaatar. 1976]

Наранцэцэг, Д., Баяртуяа, Б., Бираасүрэн, Х., Мөнх-Отгон, Д., Отгонбаяр, Т. (2023) *Төвөд хэлт сургаалын зохиолын бичвэр зүйн судалгаа* Хэвлэлд бэлтгэсэн. Д.Наранцэцэг, Б.Баяртуяа, Х.Бираасүрэн, Д.Мөнх-Отгон, Т.Отгонбаяр. Редактор Д.Цэрэнсодном. Улаанбаатар. [Narantsetseg, D., Bayartuya, B., Biraasuren, Kh., Monk-Otgon, D., Otgonbayar, T. *Tövöd helt surgaalyn zohiolyn bichver züin sudalгаа* Ulaanbaatar, 2023]

Төвөд хэлээр

[Гончигдамбийдонмэ] gung thang dkon mchog bstan pa'i sgron me (1762-1823). The Collected Works (gsung 'bum) of gung thang dkon mchog bstan ba'i sgron me.

[Ишбалжир] mi'i chos lugs kyi bstan bcos me tog phreng mdzes. //legs bshad bstan bcos phyogs bsgrigs. mtsho sngon mi rigs dpe skrun khang. zi ling. 2006

[Лувсанпэрэнлэй] blo bzang 'phrin las. blo bzang 'phrin las kyi gsung 'bum

[Лувсанцүлтим] blo bzang tshul khrims. blo bzang tshul khrims kyi gsung 'bum.

Орос хэлээр:

Бира, Ш. (1960) *Монгольская тибетоязычная историческая литература*. Улаанбаатар. [Бира, Ш. (1960) Монголчуудын төвөд хэлт түүхийн зохиол. Улаанбаатар Bira, Sh. *Mongolchuudyn tövöd helt tüühiin zohiol*. Ulaanbaatar]

Дугар-Нимаев, Ц., А. (1966) *Зерцало мудрости, разъясняющее принимаемое и отвергаемое по двум законам* (Вступительная статья, подготовка старомонгольского текста, русский перевод и примечания к нему Ц.А.Дугар-Нимаев). Улан-Үдэ.

Судалгааны тайлан

Гэр бүлийн орчин дахь үндэсний соёлын өнөөгийн байдал, чиг хандлага. Социологийн судалгааны тайлан. (2016). СУСХ. Улаанбаатар. [Current status and trends of national culture in the family environment. Ger бүлийн орчин даки үндесни союлын өнөөгийн байдл, чиг handлага. Sotsiologyn sudalgaany tailan] Sociological Research Report. (2016). University of Culture and Arts. Ulaanbaatar. 2016]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.